



МОНГОЛ ДААТГАЛ

**МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

20 20 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 20/12

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 62.1.1 болон 62.1.7 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дах заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монгол даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04-р сарын 15-ний өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, “Монгол даатгал” ХК-ийн байранд 3 давхарт хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1 Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
 - 2.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;
 - 2.4 Компанийн дүрэмд нэмэлт оруулах асуудлыг хэлэлцэн батлах;
 - 2.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журмыг батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 3 сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д хүргүүлэх өдрийг 2020 оны 03 дугаар сарын 6-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2020 оны 03 дугаар сарын 09, 2019 оны 3 дугаар сарын 24-ний өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх, 2020 оны 03 дугаар сарын 09 болон 3 дугаар сарын 24-ны өдрүүдэд өдөр тутам

6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.
- 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийн хуулбар;
- 6.2. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл танилцуулга;
- 6.3. Хурлын санал хураах хуудас;
- 6.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;
- 6.5. Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх танилцуулга;
- 6.6. Хурлын зар.
7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр, хурлын дэгийг Хавсралт №2-оор, танилцах бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-аар тус тус баталсугай.
8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2020 оны 4 дүгээр 15-ны өдрийн 15:00 цагаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалахыг ТУЗ-ийн гишүүн Б.Аюушд даалгасугай.
10. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:
Дарга: Ч.Бат-Өлзий /Гендекс ХХК/
Гишүүд: Д.Дэлгэрмаа /Гендекс ХХК/
11. Хурал зохион байгуулах комиссын даргаар /О.Эрдэнэбулган/-ыг томилсугай.
12. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /О.Эрдэнэбулган/-д даалгасугай.

Дарга: Ч.Бат-Өлзий /Гендекс ХХК/
Гишүүд: Д.Дэлгэрмаа /Гендекс ХХК/

ДАРГА



НАТАЛЬЯ ОГАЙ